

**“ТҮМЭН ШУВУУТ” ХК- ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2023 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ДҮГНЭЛТ**

/Аудитын хорооны 2023 оны үйл ажиллагааны талаар товч танилцуулга/

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны зорилго нь: Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэх, дотоод хяналтын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих, дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин, урамшууллыг тогтоох санал боловсруулах, аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлийг хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

“Түмэн шувуут” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн 2022 оны 05 сарын 17-ны өдрийн 08/2022 тоот тогтоолоор байгуулагдсан Аудитын хороо нь дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллалаа.

Аудитын хорооны дарга: ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Бакей

Гишүүд: ТУЗ-ийн хараат бус гишүүн Ц.Наран-Учрал

ТУЗ-ийн ердийн гишүүн Э.Баяржаргал

Аудитын хороо нь 2023 онд нийт 3 удаа хуралдаж 5 асуудал шийдвэрлэсэн байна.

Аудитын хороо нь чиг үүргийнхээ хүрээнд 2023 оны 09-р сарын 12-ны өдөр компанийн 2023 оны санхүү, үйл ажиллагаанд аудит хийх байгууллагыг сонгон шалгаруулах байгууллагад тавигдах шаардлагыг баталсан бол, 2023 оны 09-р сарын 27-ны өдрийн Аудитын хорооны шийдвэрээр “Түмэн шувуут” ХК-ийн 2023 оны санхүүгийн тайлан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд аудит хийхээр хүсэлтээ ирүүлсэн “Онч аудит” ХХК-ийг сонгон ТУЗ-ийн даргаар батлуулж, гэрээ байгуулсан.

ТУЗ-н дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааг эрчимжүүлэх, компанийн дотоод хяналтын тогтолцоог улам боловсронгуй болгох, Компанийн засаглалын кодексын хэрэгжилтийг хангах үүднээс гүйцэтгэх удирдлагын дор дотоод хяналтын ажилтан болон хамтран ажиллах багийг байгуулан ажиллаж байна.

Аливаа нөхцөл байдлаас шалтгаалан үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээ болон эрсдэлийг тооцоолох үүднээс “Эрсдэлийн удирдлагын заавар”-ыг батлуулсан ба үйлдвэр аж ахуй, алба нэгж тус бүр өөрсдийн эрсдэлийн төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Аудитын хороо нь чиг үүргийнхээ хүрээнд эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө болон хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд нь зөвлөмж өгч ажиллалаа.

2023 онд тус хороо нь компанийн санхүүгийн хяналтын тогтолцоог сайжруулах үндсэн чиг үүргийнхээ дагуу улирал бүрийн санхүүгийн тайлантай танилцаж үйл ажиллагаанд хяналт тавьдаг зорилгынхоо хүрээнд холбогдох ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Аудитын хорооны хурлаар тус хувьцаат компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар холбогдох албан тушаалтнуудаас ирүүлсэн санхүүгийн тайлан, бусад нэмэлт материалд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. “Түмэн шувуут” хувьцаат компани 2023 онд **113,2** сая ширхэг өндөг үйлдвэрлэсэн нь өмнөх оныхоос **16%**-иар /өмнөх онд **97.7** сая ш/өндөг /өссөн бол малын тэжээлийн үйлдвэрлэл өмнөх онтой харьцуулахад **20%**-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Мөн 2023 онд нийт **705** тн органик бордоо, **307** тн шингэн өндөг үйлдвэрлэсэн байна.

2. Бүтээн байгуулалтын тухайд СХД-ийн 21 дүгээр хороо, Их булагт байрлалтай 2 дахь шувууны аж ахуйд нэмж өндөглөгч шувууны 3 байр, дэгдээхийн 1 байрыг ашиглалтад оруулсанаар нийт өндөглөгчийн 8 байр, дэгдээхийн 2 байртай болж, ажлын байрыг 15-аар нэмсэн нь 2023 оны үйлдвэрлэлийн тоог өсгөхөд тодорхой хувь нэмрээ оруулсан байна.
3. Үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой Түмэн шувуут-2 аж ахуйд шинээр өндөгний агуулах барьсан бол төв оффис дахь өндөгний агуулахын тоог мөн нэмэгдүүлсэн нь бараа бүтээгдэхүүнээ стандартын дагуу хадгалах нөхцөлийг бүрдүүлж чадсан байна. Мөн түүнчлэн борлуулалтын машин байрлуулах дулаан зогсоол барьсан нь түрээсийн төлбөрийн зардлыг бууруулсан байна.
4. Үйлдвэрийн тоног төхөөрөмжийг сайжруулах ажлууд хийгдэж байгаа нь ажлын бүтээмж нэмэгдэх төдийгүй ажилтны хөдөлмөрийг хөнгөвчлөхөд чухал нөлөө үзүүлж байна.
5. “Хүнсний хувьсгал” хөтөлбөрийн хүрээнд Хөдөө аж ахуйн салбарыг дэмжин Засгийн газраас олгож байгаа хөнгөлөлттэй зээлд хамрагдан бүтээн байгуулалтын ажлууд, үйлдвэрлэлийн түүхий эдийн нөөцийг бүрдүүлэлтийн асуудлыг шийдвэрлэж байгаа нь маш зөв зүйтэй ажил болсон юм.
6. “Түмэн шувуут” ХКомпани нь 2022 онд 7.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бол 2023 онд 11.4 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ.

Тус компаний 2024 онд байгуулахаар төлөвлөсөн Түмэн шувуут-3 шувууны аж ахуйн бүтээн байгуулалтын ажил нь тус компанийн зах зээлд эзлэх байр суурийг улам бэхжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ хэмээн үзсэн болно.

Нэгдсэн дүгнэлт:

1. Тайлант хугацаанд “Түмэн шувуут” ХК-ийн үйлдвэрлэлийн хэмжээ, борлуулалт, цэвэр ашгийн өсөлтөнд:
 - 1.1 тайлант хугацаанд компанийн нэр хүнд, зах зээлд эзлэх байр суурийг бэхжүүлж чадсан
 - 1.2 импортын хамааралтай үйлдвэрлэлийн орц, барааны талаар авч хэрэгжүүлсэн маркетингийн бодлого эерэг нөлөө үзүүлсэн
 - 1.3 үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэхтэй холбоотой бүтээн байгуулалтын ажил тус тус нөлөөлсөн гэж үзэж байна.
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооноос “Түмэн шувуут” Хувьцаат компанийн 2023 оны санхүүгийн үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэж байна.
3. “Түмэн шувуут” ХК-ийн санхүүгийн тайлан, мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, санхүүгийн баримт материалын бүрдэл, компанийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцүүлэн баталсан заавар, журам аргачлал, стандартын дагуу үнэн зөв тайлагнасан байна.

Санал, зөвлөмж:

1. Органик бордооны үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэхийн тулд холбогдох салбар /уул уурхайн нөхөн сэргээлт, газар тариалангийн үйлдвэрлэл, хүлэмжийн аж ахуй/-ын үйлдвэрлэл эрхлэгчтэй хамтран ажиллах, төрийн байгууллагын тендерт оролцох, олон нийтэд таниулах замаар эрэлтийг нэмэгдүүлэх бодлого явуулах
2. Усалгаатай газар тариалангийн үр дүнг тооцож үр ашгийг дээшлүүлэх, шингэн өндөгний борлуулалтыг нэмэгдүүлэх зэрэг ажлыг үе шаттай зохион байгуулж ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

АУДИТЫН ХОРООНЫ ДАРГА:  А.БАКЕЙ